Уламжлалтын өвчтний түүхийг оношилгоо, эмчилгээний удирдамжтай харьцуулсан үр дүн

(Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн эмнэлгийн жишээ дээр)

Zhang Shi Ying[1], А.Ану[2], Ч.Чимэдрагчаа[2]*

[1]АШУҮИС, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль
[2]Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн
Цахим шуудан: aaanuka04@gmail.com, Утас: 88209811

Түлхүүр үг:

Уламжлалт анагаах ухаан
Оношилгоо
Эмчилгээ
Удирдамж

Товч утга:

Үндэслэл: Уламжлалтын чиглэлээр улсын хэмжээний төрөлжсөн эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж буй Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн эмнэлэгт суурилж оношилгоо эмчилгээний удирдамжийн мөрдөлтөд судалгаа хийх үндэслэл боллоо. **Зорилго:** УАУТ-ийн Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсдийн оношийн нэр төрөл, удирдамжийн хэрэгжилтийн байдлыг судлан тодруулах. **Арга, аргачлал:** Судалгааг бичиг баримтад тулгуурласан ретроспектив судалгааны загварыг ашигласан. УАУТХЭ-т 2016-2018 онд хэвтэн эмчлүүлэгчийн 300 өвчтний түүхийг санамсаргүй түүвэрлэн оношилгоо, эмчилгээг уламжлалтын оношилгоо эмчилгээний удирдамжтай харьцуулан судласан. **Үр дүн:** Өвчний түүхэнд илэрсэн үндсэн зургаан өвчний оношилгоо 30.0% (95% Cl: 24.9-35.0), цул савын өвчний оношилгоо 30.8% (95% Cl: 29.1-32.4), бусад өвчний оношилгоо 36.5% (95% Cl: 30.6-42.3)-ийг эзэлж байгаа юм. УАУТХЭ-т хэвтэн эмчлүүлэгчийн нийт 32 зүйл өвчний 15 бүлэг оношилгоо байгаа бөгөөд нийт эмчлүүлэгсдийн цагаан судасны өвчин 82 (28.18%) -ы оношилгоо хамгийн их тохиолдож байна. **Дүгнэлт:** Цагаан судасны эмгэгт Сампилноров, Зачун-13, Шингүн-5 эмүүдийг эмийн эмчилгээнд голлон хэрэглэснийг илрүүлэв. Оношилгоо эмчилгээний удирдамжтай харьцуулан үзэхэд шаардлагатай эмийг 81.2% хүртэл сонгосныг тогтоов. Бариа, зүү, соруул засал эмчилгээг цагаан судасны эмгэгт өндөр хувьтай сонгосон бөгөөд оношилгоо эмчилгээний удирдамжтай харьцуулан үзэхэд 100%-ийн гүйцэтгэлтэй байна.

Үндэслэл: Монгол Улсад 1990-ээд оноос хойш МУАУ-ыг хөгжүүлэх үндсэн чиглэл 2 удаа, «МУАУ-ны талаар төрөөс баримтлах бодлого"[1], "Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, түүний хүрээнд хийгдэх уламжлалт ба орчин үеийн анагаахын нэгдсэн онолын судалгааны төлөвлөгөө", "Уламжлалт анагаахын зонхилон тохиолдох өвчний оношилгоо эмчилгээний удирдамж" 2003 он[2], "Уламжлалт анагаахын ерөнхий мэргэжлийн эмчийн эмнэлзүйн удирдамж" 2004 он[3], "Уламжлалт анагаахын зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний стандартын эмхэтгэл" 2006 он[4], "Уламжлалт анагаах ухааны зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн удирдамж" 2013 он[5], "Зонхилон тохиолдох өвчний зүү эмчилгээний удирдамж" 2018 он[6], "Зонхилон тохиолдох өвчний зүү эмчилгээний заавар" 2022 он[7] зэрэг стандарт, удирдамж, зааврууд уламжлалтын эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглагдаж байна. Дээрх баримт бичгүүд боловсрогдон хэрэгжүүлж байгаа ч хүн амын дунд зонхилон тохиолдож буй өвчлөлүүдийн дотроос ямар өвчний аль үе шатанд, эмнэлзүйн ямар хэлбэрийнх нь үед уламжлалт эмчилгээний ямар аргууд илүү үр дүн өгч буй байдал, эмнэлгийн тусламж үйлчилгээний шатлалууд дахь үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцэж буй эсэх, стандарт удирдамж зааврын мөрдөлт хэрэгжилтэнд хийгдсэн үнэлгээ судалгаанууд доривтой хийгдэхгүй байна. Тухайн нөхцөл байдлыг харгалзан үзэж уламжлалтын чиглэлээр улсын хэмжээний төрөлжсөн эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж буй Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн эмнэлэгт суурилж оношилгоо эмчилгээний удирдамжийн мөрдөлтөнд судалгаа хийх үндэслэл боллоо.

Зорилго: УАУТ-ийн Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгсдийн оношийн нэр төрөл, удирдамжийн хэрэгжилтийн байдлыг судлан тодруулах.

Арга, аргачлал: Судалгааны ажлыг АШУҮИС-ийн МАУОУС, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн эмнэлгийг (УАУТХЭ) түшиглэн

явуулсан. Судалгааг бичиг баримтад тулгуурласан ретроспектив судалгааны загварыг ашигласан. Байгууллагад суурилсан зорилтот болон шатлалт түүвэрлэлтийн аргаар УАУТХЭ-ээр үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийн нийт эх олонлогийн тоо 6500 байсан бөгөөд алдаа гарах магадлалыг тооцон судалгаанд 1 жилд 100 үйлчлүүлэгч, нийт 2016-2018 оны хооронд хэвтэн эмчлүүлсэн 300 үйлчлүүлэгчийн өвчний түүхийг энгийн санамсаргүй түүвэрлэлтийн аргаар түүвэрлэн хамруулсан. Өвчний түүхэнд бичигдсэн эмийн болон заслын эмчилгээг Уламжлалт анагаах ухааны зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн удирдамж (2013 он)-тай харьцуулан хэрэгжилтийг тооцон дүн шинжилгээ хийсэн.

Судалгааны ажлыг АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2019 оны 12-р сарын 20-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж, судалгаа хийх Био-Анагаахын ёс зүйн зөвшөөрөл авсан (Хурлын тэмдэглэл 2019/3-13).

Статистик боловсруулалтыг Microsoft Excel 2019, SPSS 20.0 программыг ашиглан боловсруулалт хийж, үр дүнг дескриптив шинжилгээг хийв.

Үр дүн: Судалгаанд УАУТХЭ-т 2016-2018 онд хэвтэн эмчлүүлэгчийн 300 өвчтний түүхийг санамсаргүй түүвэрлэн үзэхэд дундаж наслалт 58.99±13.33 байв. Нийт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчид 7-9 хоног хэвтэн эмчлүүлсэн бөгөөд дундаж ор хоног 7.01±0.3 байна. Хүйсийн хувьд 94 (31.3%) эрэгтэйчүүд, 206 (68.7%) эмэгтэйчүүд байна.

1. УАУТХЭ-т хэвтэн эмчлүүлэгчийн оношийн үр дүн: УАУТХЭ-ийн 2016-2018 онд хэвтэн эмчлүүлэгсдийн нийт 300 өвчний түүхэнд баримтын судалгаа хийхэд үндсэн зургаан өвчин, цул сав эрхтний өвчин, толгойн өвчин, адын өвчин, цагаан судасны өвчин, эмэгтэйчүүдийн өвчин зэрэг оношийн бүлгүүдээр хэвтүүлэн эмчилж тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Өвчний түүхэнд илэрсэн үндсэн зургаан өвчний оношийн тохиолдлууд (n=300)

Оношийн бүлэг	n (%)	p утга
Язгуурын хийн өвчин		
Хий татах	4 (1.3)	
Хий долгисох	6 (2.0)	
Хий цусаар дээш хөөрөх	30 (10.0)	
Нийт	40 (13.3)	p<0.05
Язгуурын шар өвчин		
Хийгээр сарнисан шар	3 (1.0)	
Нийт	3 (1.0)	
Шар усны өвчин		
Хэрх өвчин	4 (1.3)	
Хар шар усны өвчин	1 (0.3)	
Цагаан шар усны өвчин	42 (14.0)	
Нийт	47 (15.6)	p<0.05
Нийт	**90 (30.0)**	

Өвчний түүхэнд илэрсэн үндсэн зургаан өвчний оношийн тохиолдлуудаас авч үзэхэд язгуурын хийн өвчин 13.8%, шар өвчин 1.0%, шар усны өвчин 16.1% байгаа бөгөөд нийт 30.0% (95% Cl: 24.9-35.0)-ийг эзэлж байгаа юм (Хүснэгт 1). Үүнээс харахад хий цусаар дээш хөөрөх өвчин болон цагаан шар усны өвчин статистик үнэн магадлалтай хамгийн их оношт тавигдсан байна (p<0.05).

Нийт 300 үйлчлүүлэгчийн өвчний түүхэнд 30.8% (95% Cl: 29.1-32.4) цул савын өвчний оношт тавигдснаас зүрхний өвчин 9.1%, уушгины 1.6%, элэгний 1.3%, дэлүүний 0.7%, бөөрний 16.1%, ходоодны 1.3%, цөсний 0.3%, давсагны өвчин 0.3% илэрсэн (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Өвчний түүхэнд илэрсэн цул савын өвчний оношийн тохиолдлууд (n=300)

Оношийн бүлэг	n (%)	p утга
Зүрхний өвчин		
Зүрх долгисох өвчин	13 (4.5)	
Зүрхний хатгалга	10 (3.4)	
Зүрх будангуйрах	3 (1.0)	
Зүрхний халуун	1 (0.3)	
Нийт	27 (9.1)	*p<0.05
Уушгины өвчин		
Уушгины дагшуур	1 (0.3)	
Амьсгал амаргүй өвчин	1 (0.3)	
Уушгины мэнгэр	3 (1.0)	
Нийт	5 (1.6)	
Элэгний өвчин		
Элэг дэлгэрэх	2 (0.7)	
Элэгний бор	1 (0.3)	
Элэгний хүйтэн	1 (0.3)	
Нийт	4 (1.3)	
Дэлүүний өвчин		
Дэлүүний халуун	2 (0.7)	
Нийт	2 (0.7)	
Бөөрний өвчин		
Бөөрний хий архаг	42 (14.4)	
Бөөрний халуун	4 (1.4)	
Бөөрний цайвар хаван	1 (0.3)	
Нийт	47 (15.6)	*p<0.05
Ходоодны өвчин		
Ходоод доройтох	3 (1.0)	
Ходоодонд хор харших	1 (0.3)	
Нийт	4 (1.3)	
Цөсний өвчин		
Цөсний хүйтэн шар	1 (0.3)	
Нийт	1 (0.3)	
Давсагны өвчин		
Давсагны хүйтэн өвчин	1 (0.3)	
Нийт	1 (0.3)	
Нийт	**91 (30.8)**	

Үүнээс зүрх долгисох өвчин 4.5%, бөөрний хий архаг өвчин 14.4% статистик үнэн магадлалтайгаар тохиолдож байна.

Нийт 300 үйлчлүүлэгчдийн өвчтний түүхэнд бусад өвчний оношийн тохиолдлуудаас авч үзэхэд толгойн өвчин 3%, цагаан судасны өвчин 27.3%, адын өвчин 6.0%, эмэгтэйчүүдийн өвчин 0.3% байгаа бөгөөд нийт 36.5% (95% Cl: 30.6-42.3)-ийг эзэлж байгаа юм. Үүнээс цагаан судасны өвчин бусад өвчнүүдтэй харьцуулахад статистик үнэн магадлал бүхий ялгаатай их онош тавигдсан байна. (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Өвчний түүхэнд илэрсэн бусад өвчний оношийн тохиолдлууд (n=300)

Оношийн бүлэг	n (%)	p утга
Толгойн өвчин		
Толгойн хий өвчин	5 (1.7)	
Толгойн бадгана өвчин	1 (0.3)	
Толгойн шар өвчин	3 (1.0)	
Нийт	9 (3.0)	
Цагаан судасны өвчин		
Толгойн хуян өвчин	32 (10.6)	
Их биеийн хуян өвчин	50 (16.6)	
Нийт	82 (27.3)	*p<0.05
Адын өвчин		
Саа өвчин	18 (6.0)	
Нийт	18 (6.0)	
Эмэгтэйчүүдийн өвчин		
Эмэгтэйчүүдийн хий бүрэлдсэн өвчин	1 (0.3)	
Нийт	1 (0.3)	
Нийт	**110 (36.5)**	

Дээр дүнг нэгтгэн авч үзвэл УАУТХЭ-т 2016-2018 онд хэвтэн эмчлүүлэгчийн 300 өвчтний түүхийг санамсаргүй түүвэрлэн үзэхэд нийт 32 зүйл өвчний 15 бүлэг онош байгаа бөгөөд нийт эмчлүүлэгсдийн цагаан судасны өвчин 82 (28.18%) -ы онош хамгийн их тохиолдож байна.

2. "Цагаан судасны өвчин" оноштой өвчтнүүдэд хийгдсэн эмийн эмчилгээг оношилгоо эмчилгээний удирдамжтай харьцуулан судалсан үр дүн: УАУТХЭ-т 2016-2018 онд хэвтэн эмчлүүлэгчийн 300 өвчтний түүхийг санамсаргүй түүвэрлэн үзэхэд нийт 32 зүйл өвчний 15 бүлэг онош байгаа бөгөөд нийт эмчлүүлэгсдийн дунд цагаан судасны өвчин 82 (28.18%) -ы онош хамгийн их тохиолдож байсан. Бид өвчний түүхэнд бичигдсэн эмийн эмчилгээг уламжлалт анагаах ухааны оношилгоо эмчилгээний удирдамжтай харьцуулан судалж дараах үр дүн гарлаа.

Толгойн хуян өвчинд Сампилноров эмийг 81.2%, Зачун-13 эм 25%, Мана-10 эм 18.8%, Шингүн-5 эм 50%, Агар-35 эм 25% тус тус хэрэглэсэн нь тогтоогдлоо. Харин Чагдоррилбо эмийг хэрэглэсэн тохиолдол илрээгүй байна. Үүнээс харахад уламжлалтын эм үйлдвэрлэл, эм хангамжийн үйл ажиллагааг зохистой явуулахын тулд зайлшгүй шаардлагатай болон импортоор авах уламжлалт эмийн жагсаалтыг гаргах хэрэгтэй юм.

Их биеийн хуян өвчинд Сампилноров эм 62%, Зачун-13 эм 24%, Сорогзин-25 эм 2%, Шингүн-25 эм 16%, Жонлон-5 эм 20%, Сэндэн-4 эм 24%, Танчин-25 эм 22%, Сүгмэл-3 эм 26% тус тус хэрэглэсэн байна. Харин Лиш-25 эмийг хэрэглэсэн тохиолдол илрээгүй байна. (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Эмийн эмчилгээг оношилгоо эмчилгээний удирдамжтай харьцуулан судалсан үр дүн

Оношийн бүлэг	n (%)	Өвчний түүхэнд хийгдсэн эмийн эмчилгээний тоо (%)		Удирдамжид заагдсан эмийн эмчилгээ
Цагаан судасны өвчин				
Толгойн хуян өвчин	32 (39%)	Сампилноров	26 (81.2%)	Сампилноров
		Зачун-13	8 (25%)	Зачун-13
		Чагдоррилбо	0 (0%)	Чагдоррилбо
		Мана-10	6 (18.8%)	Мана-10
		Танчин-25	1 (3.1%)	Танчин-25
		Шингүн-5	16 (50%)	
		Агар-35	8 (25%)	
Их биеийн хуян өвчин	50 (61%)	Сампилноров	31 (62%)	Сампилноров
		Зачун-13	12 (24%)	Зачун-13
		Лиш-25	0 (0%)	Лиш-25
		Сорогзин-25	1 (2%)	Сорогзин-25
		Шингүн-25	8 (16%)	Шингүн-25
		Жонлон-5	10 (20%)	Жонлон-5
		Сэндэн-4	12 (24%)	Сэндэн-4
		Танчин-25	11 (22%)	Танчин-25
		Сүгмэл-3	13 (26%)	
Нийт	**82 (100%)**			

3. "Цагаан судасны өвчин" оношtой өвчтнүүдэд хийгдсэн заслын эмчилгээг оношилгоо эмчилгээний удирдамжтай харьцуулан судалсан үр дүн: УАУТХЭ-т 2016-2018 онд хэвтэн эмчлүүлэгчийн 300 өвчтний түүхийг санамсаргүй түүвэрлэн үзэхэд нийт 32 зүйл өвчний 15 бүлэг онош байгаа бөгөөд нийт эмчлүүлэгсдийн дунд цагаан судасны өвчин 82 (28.18%) -ы онош хамгийн их тохиолдож байсан. Бид өвчний түүхэнд бичигдсэн заслын эмчилгээг уламжлалт анагаах ухааны оношилгоо эмчилгээний удирдамжтай харьцуулан судалж дараах үр дүн гарлаа. Толгойн хуян өвчинд зүү 75%, бариа 90.6%, соруул 65.6%, төөнө 62.5%, шивүүр 21.9%, самнуур 3.1%, дэвтээлэг 6.3% тус тус засал эмчилгээ хийгдсэн байна. Толгойн хуян өвчинд таван рашааны дэвтээлэг заслыг сонгон хийгдсэн. Оношилгоо эмчилгээний удирдамжид заагдсан засал эмчилгээнүүдийг өндөр хувьтай гүйцэтгэж байна.

Их биеийн хуян өвчинд зүү 100%, бариа 100%, соруул 56%, төөнө 68%, хануур 2%, шивүүр 22%, самнуур 2%, дэвтээлэг 4%, ороолт 22% тус тус засал эмчилгээ хийгдсэн байна. Дэвтээлэг заслын хүрээнд шилмүүс, барагшины рашаан эмчилгээг түлхүү хийжээ. Мөчдийн хуян өвчинд далан түрүү, халгайн ороолтуудыг өргөн хэрэглэж байна.

Үүнээс харахад Цагаан судасны өвчин оноштой эмчлүүлэгчийн заслын эмчилгээ уламжлалт анагаах ухааны оношилгоо, эмчилгээний удирдамжтай харьцуулахад бүрэн (100%) тохирч байна.

Хүснэгт 5. Заслын эмчилгээг оношилгоо эмчилгээний удирдамжтай харьцуулан судалсан үр дүн

Оношийн бүлэг	n (%)	Хийгдсэн заслын эмчилгээний тоо (%)		Удирдамжид заагдсан заслын эмчилгээ
Цагаан судасны өвчин				
Толгойн хуян өвчин	32 (39%)	Зүү	24 (75%)	Зүү
		Бариа	29 (90.6%)	Бариа
		Соруул	21 (65.6%)	Соруул
		Төөнө	20 (62.5%)	Төөнө
		Шивүүр	7 (21.9%)	Хануур
		Самнуур	1 (3.1%)	Дэвтээлэг
		Дэвтээлэг	2 (6.3%)	
Их биеийн хуян өвчин	50 (61%)	Зүү	50 (100%)	
		Бариа	50 (100%)	Зүү
		Соруул	28 (56%)	Бариа
		Төөнө	34 (68%)	Соруул
		Хануур	2 (4%)	Төөнө
		Шивүүр	11 (22%)	Хануур
		Самнуур	1 (2%)	Дэвтээлэг
		Дэвтээлэг	2 (4%)	
		Ороолт	11 (22%)	
Нийт	**82 (100)**			

Хэлцэмж: Монгол улсад 2021 оны үзүүлэлтээр уламжлалтын 294 эрүүл мэндийн байгууллага ажиллаж байгаа нь нийт салбарын үзүүлэлттэй харьцуулахад 12%-ийг эзэлж байна. 10000 хүн амд уламжлалтын ор 4.6 ноогдож, жилд 32029 хүн хэвтэн эмчлүүлсэн. Уламжлалтын их эмч 1142 ажиллаж байгаа нь нийт эмч нарын 8.8%-ийг эзэлж, жилд УАУ-ны чиглэлээр тусламж үйлчилгээ үзүүлсэн тоо 53659 (0.8%) байгаа юм. Мөн эрүүл мэндийн даатгалын сангаас 14.9 тэрбум төгрөгний санхүүжилт авсан нь нийт санхүүжилтийн 2.5%-ийг эзэлжээ[8].

Уламжлалтын эмнэлгийн тусламж үйлчилгээний нэр төрлийг харьцуулан авч үзвэл мэдрэлийн, шээс бэлгийн, зүрх судасны, хоол боловсруулах, амьсгалын замын эрхтэн системийн эмгэгүүдэд тодорхой хувь хэмжээгээр өөрийн онцлог бүхий 4 ерөндөгөөр эмчилгээ үйлчилгээ үзүүлж байгаа нь тогтоогдов. Тухайлбал УАУТХЭ нь үндсэн зургаан өвчин 30.0% (95% CI: 24.9-35.0), цул савын өвчин 30.8% (95% CI: 29.1-32.4), бусад өвчин 36.5% (95% CI: 30.6-42.3) эзэлж байна. Үүнээс зүрх долгисох өвчин 4.5%, бөөрний хий архаг өвчин 14.4% статистик үнэн магадлалтай илүү илэрч байна.

Уламжлалтын эмзүйн тусламж үйлчилгээг оношилгоо эмчилгээний удирдамжтай харьцуулахад эмүүдийн хэрэглэсэн хувь хэмжээ харилцан адилгүй байгаа нь тогтоогдсон. Цаашид уламжлалт эмийн хангалт хүртээмжийг сайжруулах үүднээс зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг баталж нөөцийг бүрдүүлэх, үйлдвэрлэлийн төлөвлөлтийг боловсронгуй болгох, түүхий эдийн хангалт нөөцийг зохицуулах, зарим эмүүдийг импортоор авах үйл ажиллагааг цогц байдлаар төлөвлөх шаардлага үүсчээ.

Судлаач Ш.Адъяасүрэн (2014) нарын судалгаагаар УА-ны их эмч нарын ажлын ачаалал 30% нь маш их, 50% их ачаалалтай ажиллаж байна. УА-ын их эмчийн ажлын байрын тодорхойлолтыг жишиг хэлбэрээр ЭМБ-ууд гаргасан боловч ажил үүргийн хуваарь хэт ерөнхий, түвшний ялгаагүй ур чадвар бага шаардсан механик ажлууд ихтэй, ажлын байрны тогтсон норм норматив байхгүй, ажлын гүйцэтгэл, ажлын ачаалал, тусламж үйлчилгээний

чанар хүртээмжийг үнэлэх нөхцөл бүрдээгүй байгааг илрүүлсэн[9].

Дээрх судалгаатай холбоотой цаашид уламжлалтын тусламж үйлчилгээний шатлалын ялгааг гаргах, шатлал бүрд тохирсон эмчийн ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж батлуулах, эмч нарыг төрөлжсөн мэргэжлийн сургалтанд төлөвлөгөөтэй хамруулж ур чадвар шаардсан эмийн болон заслын эмчилгээний нэр төрөл, үр дүнг нэмэгдүүлэх хэрэгцээ байгааг тогтоолоо.

Дүгнэлт: УАУТХЭ-т 2016-2018 онд хэвтэн эмчлүүлэгчийн 300 өвчтний түүхийг санамсаргүй түүвэрлэн үзэхэд цагаан судас, бөөрний, зүрх судасны эмгэгтэй өвчтнүүд эмнэлгийн тусламж үйлчилгээг түлхүү үзүүлсэн байна. Үүнээс цагаан судасны эмгэгт Сампилноров, Зачун-13, Шингүн-5 эмүүдийг эмийн эмчилгээнд голлон хэрэглэснийг илрүүлэв. Оношилгоо эмчилгээний удирдамжтай харьцуулан үзэхэд шаардлагатай эмийг 81.2% хүртэл сонгосныг тогтоов. Бариа, зүү, соруул засал эмчилгээг цагаан судасны эмгэгт өндөр хувьтай сонгосон бөгөөд оношилгоо эмчилгээний удирдамжтай харьцуулан үзэхэд 100%-ийн гүйцэтгэлтэй байна.

Ном зүй:

1. *Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого. Нийгмийн эрүүл мэндийн эрх зүйн лавлах. 2013 он, х.9-11*
2. *УАУТХ. Уламжлалт анагаахын зонхилон тохиолдох өвчний оношилгоо эмчилгээний удирдамж. УБ хот, 2003 он*
3. *Д.Цэрэндагва. Уламжлалт анагаахын ерөнхий мэргэжлийн эмчийн эмнэлзүйн удирдамж. УБ хот, 2004 он*
4. *Монгол улсын стандарт. Уламжлалт анагаахын зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний стандартын эмхэтгэл. УБ хот, 2006 он*
5. *УАУТХ. Уламжлалт анагаахын ерөнхий мэргэжлийн эмчийн эмнэлзүйн удирдамж. УБ хот, 2013 он*
6. *УАУТХ. Зонхилон тохиолдох өвчний зүү эмчилгээний удирдамж. УБ хот, 2018 он*
7. *УАУТХ. Зонхилон тохиолдох өвчний зүү эмчилгээний удирдамж. УБ хот, 2022 он*
8. *Монгол улсын эрүүл мэндийн үзүүлэлт. УБ хот, 2021 он*
9. *Ш.Адъяасүрэн. Уламжлалт анагаахын их эмчийн ажлын ачааллыг судалсан судалгааны зарим үр дүн: АУ-ы магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. УБ.: Эрхэс, 2015 он*

Results compared with conventional medical history for diagnosis and treatment guidelines

(On the example of the hospital of the Institute of Traditional Medicine and Technology)

Zhang Shi Ying[1], Anu A[2], Chimedragchaa Ch[2]

[1]MNUMS, School of International Mongolian Medicine
[2]Institute of Traditional Medicine and Technology
E-mail: aaanuka04@gmail.com, Tel: +976-88209811

Background: Based on the hospital of the Institute of Traditional Medicine and Technology, which provides state-level specialized medical care in the field of traditional medicine, there is a basis for conducting research on the implementation of diagnostic and treatment guidelines.

Aim: To study and clarify the status of the implementation of the guidelines and the types of diagnoses of patients admitted to the ITMT Hospital.

Materials and Methods: The research work was carried out with the support of the Mongolian International School of Medicine of the National University of Medical Sciences and the Hospital of ITMT. The study used a retrospective, document-based research design.

Results: A random sampling of 300 patients' histories of inpatients at Institute of Traditional Medicine and Technology in 2016-2018 revealed 15 groups of 32 types of diseases, and white blood vessel disease was the most frequent diagnosis of 82 (28.18%) among all treatments. In the medical history of 300 clients, 30.8% (95% Cl: 29.1-32.4) were diagnosed with solid vessel disease, including heart disease 9.1%, lung 1.6%, liver 1.3%, spleen 0.7%, kidney 16.1%, stomach 1.3%, gall bladder 0.3%, bladder disease was found in 0.3%6. We have compared the therapeutic treatment recorded in the medical history with the diagnostic and therapeutic guidelines of traditional medicine and the following results have been obtained. There are 15 groups of diagnoses of a total of 32 types of inpatients at Hospital of ITMT, and white blood vessel disease is the most frequent diagnosis of 82 (28.18%) of all patients treated.

Conclusion: It was discovered that Sampilnorov, Zachun-13, and Shingun-5 drugs were mainly used in the treatment of white blood vessels. When comparing the diagnosis with the treatment guidelines, it was determined that the necessary drugs were chosen from 81.2%. Massage, acupuncture, and cupping are 100% effective compared to diagnostic and treatment guidelines.

Keywords: Traditional medicine, Diagnosis, Treatment, Guidelines